



ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДЭД

**УЛСЫН НЭГДҮГЭЭР  
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027  
И-мэйл: info@fchm.edu.mn

2024.09.27 № 1/1499  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Тодруулга өгөх тухай**

Тус эмнэлгээс зарласан ЭМЯ/20240102047 дугаар бүхий тендерийн баримт бичгээс тендерт оролцогч компани:

"Тус Соронзон резонанст томографийн аппаратын техникийн үзүүлэлтийн шаардлагын 1. Magnet System хэсэгт: "Zero helium boil off буюу гелийн буцлалтыг тэглэх технологитой байх. /Гелийн хий ууршилтгүй байх/" гэж шаардсан байна. Гэтэл сүүлийн 5 жилийн хугацаанд Дэлхий дахинд дотроо битүүмжлэгдсэн, квенч болох боломжгүй, маш бага хэмжээний (0.7-7.9 литрийн хооронд) хөргөлтийн шингэн Гелий агуулсан 1,5Т хүчин чадалтай MRI аппаратууд (Siemens Magnetom Flow 1,5T, Philips Ambition 1.5T, Wandong i\_Vision 1.5T зэрэг) зах зээлд нэвтэрсэн. Энэ загварын аппаратуудын Helium free технологийн давуу тал нь (одоо зарлагдсан байгаа тендерт шаардсан байгаа Zero boil off технологитой харьцуулахад) зөвхөн хэвийн ашиглалтын явцад шингэн Гелий алдагдахгүй байхаас гадна янз бүрийн эрсдэлт хүчин зүйлс (тог удаан хугацаагаар тасарсан, том жижиг хэмжээтэй ямар нэг метал эд зүйлс соронзонд татагдаж наалдсан г.м.) үүссэн тохиолдолд Соронзон оронг буулгах, эргүүлж үүсгэхэд шингэн Гелийн алдагдал үгүй, мөн квенч (соронзны дотор байгаа 1200-2000 литр шингэн Гелий гадагш цацагдах) үүсэх эрсдэлгүй маш том давуу талуудтай.

Асуулт: Энэ тендерт Helium free технологитой, бусад бүх үзүүлэлтүүд нь энэ тендерийн техник шаардлагуудыг хангах 1,5Т MRI аппарат санал болгосон тохиолдолд энэ нь давуу тал болох уу? Учир нь тухайн технологийн MRI аппарат танай зарласан байгаа тендерийн 5,5 тэрбум төгрөгийн төсөвт багтах ч өмнөх үеийн Zero boil off технологиор хийгдсэн MRI аппаратуудаас илүү үнэтэй тул бодлогоор дэвшилтэт технологийг дэмжихгүй бол үнээр хямд байх боломж байхгүй" гэсэн тодруулга авах хүсэлтийг ирүүлсэн.

Хариулт: Тус эмнэлгийн тендерийн баримт бичигт тендерт оролцогчид "давуу тал" гэж тооцон үнэлэх шалгуур, үзүүлэлтийг заагаагүй тул оролцогчийн өөрийн тодорхойлсон эсхүл баримт бичиг ирүүлсэн аливаа давуу талд тооцуулах хүсэлтийг тендерийн үнэлгээнд харгалзах үзүүлэлт болгохгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БЯМБАСҮРЭН



002653